



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1152

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.5 дахь заалт, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уламжлалт анагаах ухааны “Хануур засал эмчилгээний заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Д.Цэрэндагва/-д тус тус даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийг батлагдсан төсөвтөө багтаан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141210760

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
03 дугаар сарын 25 өдрийн  
1152 дугаар тушаалын хавсралт

## ХАНУУР ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

### Нэг. Үндэслэл

Хануур засал нь бүх биед тарсан өвчний хорыг цусны уураар гаргаж засах буюу хэсэг газарт тогтонгишиж шунасан өвчний муу цусыг өвчтний биед ханаж болох судлын бэлчирийг сонгож цус гаргах засал юм. Хүний биед хануур засал эмчилгээний 77 нэр төрлийн судал байдаг.

Хануур засал нь өвчний хор, урхаг, муу цус, түүний уурыг гадагшлуулан биеийн доторх амьд эд, эсийн тодорхой хэсэг гадагш гарах учраас түүнийг хэтрүүлэх, дутаах цаг нарыг нь олоогүйгээс биеийн дотоод хэм хэмнэл алдагдах тул сайтар анхааран хануур хийх нь эмчилгээний чухал ач холбогдолтой.

### Хоёр. Нэр томъёоны тайлбар

- 2.1 Хануур засал - биеийн тодорхой хэсгийг боож цусны эргэлтийг саатуулан зогсонги болгож чинэрүүлсний дараа венийг хатгаж цус авдаг бие заслын арга
- 2.2 Хануур хийх - судас хатгах
- 2.3 Хануураар эмчлэх - уламжлалт хануурын аргаар эмчлэх
- 2.4 Хавиргалан ханах арга: Ханах судлын бодит байдлыг харгалзан аль зохимжтой хажуу /баруун, зүүн/ талаас нь хагална.
- 2.5 Голд нь хагалж ханах арга: Хануурын ирийг судлын энг дагуулан голд нь хагална. Энэ аргаар голдуу магнай, шанаа, шагай, бугуй зэрэг булчин мах багатай газар ханана.
- 2.6 Хоёр хагалж ханах: Эхлээд арьсыг хагалаад дараа нь судсыг нь хагална.
- 2.7 Зөрүү ханалж ханах: Нарийвтар судсыг зөрүүгээр /ташуу/ хагална.
- 2.8 Хөндлөн тасалж ханах арга: Маш нарийн судсыг ханахад хэрэглэнэ.

### Гурав. Хануур засал эмчилгээний ерөнхий үүрэг, зарчим

#### 3.1 Үүрэг:

- 3.1.1 Элэг хамгаалах
- 3.1.2 Шарын халууныг дарах
- 3.1.3 Муу цусыг гаргаж бие махбодийг цэвэршүүлэх
- 3.1.4 Өвдөлт намдаах
- 3.1.5 Муу цусны урхагийг арилгах



### 3.2 Зарчим:

3.2.1 Элэгний эсийн үхжлийг багасгаж, цэсний зогсонгишлыг бууруулан элэг хамгаалах үйлдэлтэй.

3.2.2 Цусны хоруу чанарыг гарган венийн судасны хавхлагуудыг сэргээнэ.

3.2.3 Мэдрэлийн эсүүдийг цочроож, биеийн эсэргүүцлийг дэмжин цусны эргэлтийг сайжруулна.

3.2.4 Цус сэлбэлтийн нэгэн хэлбэр болдог дутуу боловсорсон цусны элементүүдийг гадагшлуулж чөмөг, дэлүүнд дахин цусны дүрст элементийг үйлдвэрлэх боломж олгодог.

### Дөрөв. Хануур засал эмчилгээний оношлогоо

4.1 Уламжлалт анагаах ухааны асуух, үзэх, хүрэлцэх шинжилгээгээр өвчний мөн чанарыг тогтооно. Судас түргэн, дэлгэрэнгүй, эрчимтэй лугшина.

4.2 Бодит үзлэг, асуумжинд цусархаг хам шинжийн өөрчлөлт байгаа эсэх

#### Хүснэгт 1. Онош тавих 10 их баримтлал

| №  | 10 их баримтлал            | Гадар шинж, мөн чанар   |
|----|----------------------------|---|
| 1  | Шалтгаан                   | Цус шарын чанартай халуун дэлгэрсэн өвчнүүд   |
| 2  | Нөхцөл                     | Хуурай хурц чанартай хоол унд хэтрүүлэн хэрэглэсэн                                  |
| 3  | Орон байр                  | Хуурай, халуун, бүгчим, чийглэг   |
| 4  | Өвчин хөдөлсөн цаг         | Өдөр дунд шөнө дунд   |
| 5  | Бие махбодын өвөрмөц чанар | Шарын өвөрмөц чанартай, идэр залуу насны хүмүүс                                     |
| 6  | Нас                        | 18-50 насны хүмүүс  |
| 7  | Өвчин орших орон           | Биеийн дунд хэсэг, элэг цэс   |
| 8  | Өвчин хөдлөх нөхцөл        | Намрын улиралд, гал наранд халах, халуун хурц, исгэлэн амттай хоол унд хэрэглэх     |
| 9  | Идээ ундаа явдал мөр       | Өөх тостой хоол унд, айраг, тарвага, адуу хонины мах, архи, шар айраг, гүүний айраг |
| 10 | Шээсэнд гарах өөрчлөлт     | Уур үнэр ихтэй, өтгөн шар, өрөм, язмаг ихтэй  |

## Хүснэгт 2. Халуун чанартай өвчнийг шинжлэн тодорхойлох зарчим

| Гадар шинж  | Дотор шинж   |
|---|--|
| <p>Арьс салст шар, улайсан харласан, боровтор</p> <p>Нүд: Уураглаг бүрхүүл шар туяатай, өөхөн унжлага үүссэн, улайсан, биеийн илч ихэссэн, хумсанд зураас суусан.</p> | <p>Цус шарын билэг чанар давамгайлсан, халуурах, цээжээр өвдөх, ам цангах, уруул хатаж омголтох, хэлэнд зузаан шар өнгөр тогтох, хүчтэй өвдөлтийн шинжүүд илрэх.</p> |

## Хүснэгт 3. Шээсийг үзэж шинжлэх

| Халууны цаг |              |               |                                | Халуун = Хүйтэн       |   | Хөрсний дараа                     |  |   |
|-------------|--------------|---------------|--------------------------------|-----------------------|---|-----------------------------------|--|---|
| Өнгө        | Уур          | Үнэр          | Хөөс                           | Өрөм                  | Язмаг   | Х. цаг                            | Х. ёс                                  | Х. Сүүл   |
| Шар         | ++<br>Уур их | ++<br>Үнэртэй | ++<br>Хөөс жижиг түргэн арилна | ++<br>Өрөм зузаан шар | +++<br>Язмаг шээсний дунд хөвөн зулсан мэт цагаан өнгөтэй | -<br>Хувирах цаг нь хөрсний дараа | -<br>Хувирах ёс нь савны нимгэн талаас | Хувирсны сүүлд нь өтгөн шар өнгөтэй, уур үнэр ихтэй |

### Тав. Хануур засал эмчилгээ хийхээс өмнөх бэлтгэл

#### 5.1 Хануур заслын өмнө эмчлүүлэгчийн холын бэлтгэл

- 5.1.1 Боловсроогүй халууныг боловсруулж, тамирын цус өвчний цус ялгарахгүй бол ялгах тан уулгаж ханана. Өвчний цус, тамирын цус хоёрыг ялгахад тус тус танг хэрэглэнэ.
- 5.1.2 Өвчний цус тамирын цусыг ялгахад шар тан
- 5.1.3 Хий халууныг боловруулахад лидэр
- 5.1.4 Бадган цусыг ялгахад мана, лидэр
- 5.1.5 Харшилдсан ба хурмал өвчний цусыг ялгахад жүр үрийн тан
- 5.1.6 Цус шарыг ялгахад балига, лидэр
- 5.1.7 Өвчний цусыг судасны сүвд эргүүлэхэд дан бибилэн
- 5.1.8 Өвчнийг түргэн боловсруулахад лидэр
- 5.1.9 Боловсроогүй цусны цөвийг ялгахад мана, гандигар, лидэр жүр үр
- 5.1.10 Шарын халууныг боловсруулахад Дэгд-3
- 5.1.11 Өвчний цус тамирын цусыг ялгахдаа засал хийхийн урьд шөнө бибилингийн танг өгч муу цусыг өөр өөрийн ханах оронд татана.
- 5.1.12 Тан эмийг уулгахад тохиромжтой өдөр нь 3-5 хоног илүү тохиромжтой байдаг.



5.1.13 Тан эмийг уулгахгүй ханавал өвчний цус гадагшлахгүй, тамирын цус гадагшилж хий түрээд тамир барагдаж, өвчний урхаг эрхтэнд үлдсэнээр өвчин цаашид даамжрах болно.

## 5.2 Хануур засал хийх ойрын бэлтгэл

Ойрын бэлтгэл гэдэг нь ханахын өмнө эмчлүүлэгчид юу анхаарах ёстой гэдгийг тодруулж өгдөг. Эмнэлзүйн харилцааны ур чадварын дотроос засал хийх, эмчлүүлэгчтэй харьцах өвөрмөц харилцааны ур чадварыг эзэмшсэн байх ёстой.

## 5.3 Хануур засал эмчилгээнээс өмнө зайлшгүй хийх шинжилгээ

5.3.1 Цусны ерөнхий шинжилгээ

5.3.2 Шээсний ерөнхий шинжилгээ

5.3.3 Цусны бүлэгнэлтийн хугацааг тодорхойлж бүлэгнэлтэнд үнэлгээ өгөх

5.3.4 Бодит үзлэг, асуумж /цусархаг хам шинжийн өөрчлөлт илэрсэн эсэх/

## Зургаа. Хануур засал эмчилгээг дараах өвчний үед үзүүлнэ.

6.1 Хануур засал хийхэд хувь хүнд тохирох гадаад орчин болон нас, хүйс, явдал мөр, идээ ундаа:

- Идэр залуу, тарган, тамир тэнхээ сайн хүмүүс,
- Гал наранд шарагдсан биеийн хүчний ажил хийсэн,
- Халуун өдөр буюу халууны цагт хэтэрхий унтсан,
- Халуун хуурай орчинд удаан хугацаагаар амьдарсан,
- Хурц, халуун, тослог, эхүүн, исгэлэн, давслаг идээ ундаа үргэлж хэрэглэдэг,
- Бэртэж гэмтсэн, мэсний шарх туссан,
- Товчилвол цус шарын өвөрмөц чанартай хүмүүст хануур засал хийхэд тохиромжтой.

## 6.2 Заалт

- Толгойн өвчин
- Нүдний өвчин
- Хамрын өвчин
- Цус шарын гэмээр шүд, чих өвдөх, муу цусны гэмээр уруул харлаж үлэхрэх, уушигны өвчин
- Элэгний өвчин
- Дэлүүний өвчин
- Бөөрний өвчин, бөөрний гэмтсэн халуун
- Зүрхний өвчин
- Ходоодны цус шарын халуун чанартай өвчин, хошногоны гүвдрүү (шамбарам), нурууны өвчин
- Хөлийн бам өвчин
- Арьсны халуун шар усны гаралтай өвчнүүд

## 6.3 Хориглох заалт:

6.3.1 Тамир тэнхээ доройтсон, бие хэл, сэтгэлийн үйл хэтэрсэн, жирэмсэн эмэгтэйчүүд, настайчууд, хүүхэд, уур дутагдалтай, тэжээлийн доройтол, хөнгөн,



ширүүн, сэрүүн, идээ ундааг үргэлж шүтсэн, цус их алдсан, цус багатай, цусны өвчтэй, цус гоожимтгой хам шинж илэрдэг, сэтгэцийн эмгэгтэй, өвчтөнд хануур засал хийхгүй.

#### 6.3.2 Хануур засал хийхгүй өвчин:

- Цус багадалт
- Цусны өвчин
- Хорт хавдар
- Жирэмсэн эмэгтэй
- Цайвар хаван, их архаг, галын илч буурсан өвчин
- Сэтгэцийн өвчин
- Хий бадганаас болсон хүйтэн чанартай өвчин

6.3.3 Цээрлэх цаг үе (ханаж үл болох халуун): Хэдийгээр цус шараас болсон өвчнүүдийг ханаж болох боловч доорх 7 зүйлийн өвчнийг ханаж болохгүй.

- Эс боловсорсон халууныг ханавал булингартай.
- Ямар ч хижгийг ханавал цулд өвчин бууна.
- Хямарсан халуун “муу цус”, тамирын цусыг ялгахгүйгээр ханавал тамирын цусыг гадагшлуулна. Халууныг сарниулах, өвчний цус хоцорч халууны урхаг ч гарч чадахгүй.

- Хоосон халууныг ханавал хий долгисоод өвдөж хатгуулна.
- Нян халууныг ханавал үлдсэн цус нь амин судсанд гүйнэ.
- Хорын халууныг ханавал өвчин сарних бөгөөд урхаг нь гарч чадахгүй.
- Тамир дорой өвчтөнг ханавал амь насанд аюул учирна.

#### 6.3.4 Бусад хориглох зүйл

- Бэрх оньс, судасны зангилаа, ариутгаагүй зүйлээр хануур засал хийх, хэт цатгалан, хэт өлсгөлөн, даарч жихүүцэх, айж цочсон даруйд, туулга, бөөлжүүлжэг зэрэг 5 үйл хийсэн үед хануур засал хийхгүй.
- Ханах цаг, өвчний үе шатыг тохируулахгүй хануур засал хийвэл дараах хүндрэл гарна.
  - Ханах цаг эртэдвэл хий халуун шургана.
  - Ханах цаг хожимдвол “муу-цусыг” судасны сүвээр тархааж өвчний урхаг хоцорно.
  - Халууны хүч их байхад ханах засал хийвэл судас ба цулыг үгээрлүүлж (идээлүүлж) илжрүүлэх аюултай.
  - Ханах цаг, өвчний ханах засал хийх үе шатыг зөв тодорхойлох нь өвчний эдгэрэлд сайнаар нөлөөлөөд зогсохгүй цаашид гарах хүндрэлээс урьдчилан сэргийлнэ.

### **Долоо. Хануур засал эмчилгээг үзүүлэх байгууллага**

7.1 Хануур засал эмчилгээг уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд

7.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 /15.1.6, 15.1.9-өөс бусад/-д заасан эрүүл мэндийн байгууллагууд



## **Найм. Хануур засал эмчилгээний үед хэрэглэгдэх зүйл**

### **8.1 Цус ялгах тан**

### **8.2 Хануур засал хийх багаж**

Хануур засал хийхэд ханах гэж буй судасны орших газрын онцлогийг харгалзаж багажийг сонгоно. Шулуун болон цүдгэр гэдэстэй, тахир, гурвалжин иртэй зэрэг нэг удаагийн мэс заслын хутгаар ханах заслыг хийж байна.

- Шулуун иртэй хутгаар гар, хөлийн судсыг ханана.
- Цүдгэр гэдэстэй хутгыг өнгөц, бүдүүн судсыг ханахад хэрэглэнэ.
- Тахир иртэй (шинийн хоёрны сар адил) хутгаар төвөнхийн судсыг ханахад тохиромжтой.

- Гурвалжин иртэй (жад хэлбэрийн) хануурын хутгаар булчингийн гүнд байрлах хамар, шүдний судсыг ханана.

### **8.3 Ариутгасан материал /ариутгасан бөмбөлөг, самбай, тариур, зүү, иод, спирт, бээлий, хавчаар, хямсаа, наалдах тууз/**

### **8.4 Чангалуур**

### **8.5 Даралтны аппарат, чагнуур**

### **8.6 Цус алдалтыг тогтоох эмүүд**

### **8.7 Цусны бүлэгнэлтийн систем оролцдог хүчин зүйлүүдтэй төстэй бодисууд**

### **8.8 Фиберинолизин процессийг саатуулдаг эм**

### **8.9 Цус тогтоох үйлдэлтэй уламжлалт эмийн жор, эмийн ургамалууд**

### **8.10 Цус зуурмаг чанарыг ихэсгэх эм**

### **8.11 Ханах засал хийх өрөөний халдвар хамгаалалын дэглэм**

### **8.12 Шинжилгээнд цус авах хуруу шил, бөөрөн таваг**

## **Ес. Хануур засал эмчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаа**

**9.1** Монгол Улсад мөрдөгдөж байгаа эрүүл мэндийн холбогдолтой хууль тогтоомж, тушаал, журам заавар, холбогдох стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж, хүн амд чанартай тусламж үйлчилгээ үзүүлнэ.

**9.2** Хануур засал эмчилгээ үзүүлэхэд шаардлагатай өрөө, тасалгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг холбогдох стандартад заасны дагуу бүрдүүлэн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх нөхцөлөөр хангана.

**9.3** Хануур засал эмчилгээг эрүүл мэндийн байгууллага нь амбулатори, өдрийн, хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр үзүүлнэ.

## **Арав. Хануур засал эмчилгээний бэлтгэл ба үйлдлийн технологи**

**10.1** Агааржуулсан гэрэлтэй дулаан өрөөнд эмчилгээг хийнэ. Эмчлүүлэгчийн нас, бие, өвчний онцлог, ханах судалт тохирсон нэг удаагийн хутгыг сонгоно.

**10.2** Эмчлүүлэгчийн сэтгэл санааг бэлтгэж хийх гэж буй үйлдлийг таниулна.

**10.3** Эмчлүүлэгчийн эмчилгээ хийхэд тохиромжтой байрлалаар суулгах, зогсоох эсвэл хэвтүүлнэ.



**10.4** Эмч гараа угааж, халдваргүйжүүлээд, тухайн эмгэгийг анагаахад болон эмчлүүлэгчид тохирох нэг удаагийн хутга сонгоно.

**10.5** Үйлдлийн технологи:

10.5.1 Цус ялгах танг уулгах: 3 үрийн танг (өвчний мөн чанар, эмчлүүлэгчийн өвөрмөц чанарт тохируулан хэрэглэх танг эмчийн заавар зөвлөгөөний дагуу сонгоно.) өдөрт 1-2 грамыг 200 гр усанд чанаад 100 гр хүртэл ширгээгээд өдөрт 3 удаа ууна. Цус ялгах танг 3-5 хоног уулгана. Тан уусан эмчлүүлэгчид гаж нөлөө илэрвэл даруй зогсооно.

10.5.2 Эмчлүүлэгчийг бэлтгэх:

Эмчлүүлэгчид үзлэг (артерийн даралт хэмжих, судас барих) хийж зөв байрлуулна (суулгах болон бусад), ханах судасны байршлыг олж ханах цэгээ зөв тодорхойлсны дараа ханах орноос 3 хуруу дээгүүр чангалуур тавьж 3-5 минут болгоод дараа ханах талбайг ариутгана. Зөв сонгосон ханах багажаар ариун нөхцөлд ханаж цус гаргана.

10.5.3 Хануурын боолт хийх:

- Ханах судасны орноос 3 хуруу зайд зүрхэнд ойр талд нь арьс болон судсыг мушгихгүйгээр тэгш дарж, чанга сулыг тэнцүүлэн бооно.
- Дараа нь судсыг хөнгөн илж, тодрон чинэрэх үед ханах хэрэгтэй. Хэрэв боохгүйгээр эсвэл боомогцоо ханавал судас оногдохгүй, судас болон арьсыг мушгируулж боовол цус гарахгүй зэрэг хүндрэл гарч болно. Иймд боолтыг зөв хийх нь хануурын хүндрэл гарахаас урьдчилан сэргийлнэ. Тухайлбал магнайн судас, зулайн судсыг ханахад хөмсөгний дээгүүр нарийн ороолтоор ар тийш нь татаж бооно.
- Гүрээний судсыг ханахад сугавчилсан боолт эсвэл солбиж сугавчлан боож болно.
- Хэлний судсыг ханахдаа хэлийг хулсан хавчуураар хавчаад дээш нь эргүүлж ханах ба савслагат хануур гэдэг.
- Мөрний судсыг ханахдаа хонин сүүл булчингийн доогуур нарийн боолтоор бооно.

10.5.4 Хануур заслын сүүлийг шийдвэрлэх:

- Хануур засал хийж дууссаны дараа ариутгасан самбай тавьж боолт хийнэ.
- Боолтын гадуур нь наалтуураар наалт хийж, даралттай боолтын аргаар давхар бооно.

10.5.5 Ханасан цусыг шинжлэх: Ханаж гарсан цусанд дараах зүйлийг шинжилнэ.

- Цусны өнгө
- Цусны хөөс
- Цусны наалдамхай чанар
- Цусны бүлэгнэлт
- Ханасан цусны гарч буй байдал
- Цусанд байгаа бусад зүйл (цөс, салс, гэх мэт)
- Цусны үнэр
- Гарч буй цусны хэмжээ
- Цус өөрөө аяндаа зогсож буй эсэх



10.5.6 Хануур засал хийсний дараа идээ ундаа, явдал мөрийн дэглэм сахина.

- Эмчлүүлэгчийг тайван байлгаж, хоол цай идүүлнэ.
- Хануур засал хийснээс хойш 1 сарын хугацаанд ширүүн явж хөдлөх, хүнд хөдөлмөр хийх, бороо усанд норох, хүйтэн усанд хөл гараа дүрэх, халуун наранд халах, уурлах зэргийг хориглоно.
- Хэрвээ шарх бохирдсон бол цэвэр боолт хийж өгөхөөс гадна гиван, шудаг, зандан, дагша, ларзи, домтийг найруулан түрхэхээс гадна дотроос нь эм уулгана.
- Муу цус үүсгэхгүйн тулд гашуун цай, архины сувсыг тэвчих.
- Хиншүү, хярвас, бузар адын хорлолд өртөхөөс сэргийлэх
- Хануур заслын гамыг 3-6 сар цаашилбал нэг жил хүртлэх хугацаанд барина.

#### **Арван нэг. Анхаарах зүйл:**

11.1 Хүний өвөрмөц чанарыг зөв тодорхойлох;

11.2 Өвчний үе шатыг зөв тодорхойлж халуун хүйтнийг нь ялган боловсроогүй халуун байвал боловсруулж ханах;

11.3 Хий, шар, бадган махбодийн аль нэг илүү давамгай хямарсан байна гэдгийг анхаарч цус ялгах тангаа зөв тохируулан өгөх;

11.4 Ханах цаг, өдрийг анхаарч эмчлүүлэгчтэй зөвшилцсөн байх;

11.5 Эмч, эмчлүүлэгч хоёрын жил харш эсэхийг анхаарах;

11.6 Хануур засал хийхээс өмнө ханах судас түүний оронг зөв тодорхойлон үнэлэлт өгч, түүнд тохирсон хануурын багаж сонгоно.

#### **Арван хоёр. Хануур заслын явцад гарах хүндрэл**

12.1 Эмчийн гардан үйлдэлтэй холбоотой гарах хүндрэл:

- Цус үл гарах
- Судас тасарч цус алдах
- Хавдах, арьсан дор цус хурах
- Оньс гэмтээх
- Ханасан судасны хэсэгт шарх бохирдох

12.2 Эмчлүүлэгчтэй холбоотой гарах хүндрэл:

- Хануур заслыг хэтрүүлвэл хий босох, цусны тамир доройдох, цус багадах
- Хануур засал дутвал үхсэн цус гарахгүй өвчин болж хоцорно.
- Элэгний бэтэг, мүгво, яр гүвдрүү, сүрьеэ, идээт өвчнүүдийг сэдээнэ.
- Хануур засал илүүдвэл тамирыг дарж хий түрж галын илчийг сөнөөнө. Хүйтэн бэтэг, ухаан алдах, усан хаван болж хүндэрнэ.
- Хануур засал буруудах нь ханах заалтгүй өвчнийг ханасан, цагаас нь урьдаж ханах, цагийг нь өнгөрөөж ханавал өвчин архагшина.
- Ухаан алдах. Хануур засал хийж буй үед эмчлүүлэгчид зөв тайлбарлаж сэтгэл зүйн бэлтгэл хийлгээгүйгээс айж ухаан алддаг. Энэ үед цусыг даруй зогсоож цэвэр боолт хийж, орчны агаарыг тавьж өгөх нүүрэнд хүйтэн усаар зохих, утлага хийх, төөнө, зүү тавих арга хэмжээ авна.



- Хий түрвэл хийн бэлчэрүүдэд үрийн тос түрхээд илэх буюу бурамтай эм уулгана. Эсвэл бурмын архи буюу бурмын архи уулгана.

**Арван гурав. Үйлдлийн гардан гүйцэтгэгч**

Уламжлалт анагаахын заслын мэргэшсэн эмч гүйцэтгэнэ.